

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам  
Утас: 88114867 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/235  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ Л.БАЯРСАЙХАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлж байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 39,149.3 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эм 42,244.2 мянган төгрөг, тоног төхөөрөмж 26,683.8 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, нийгмийн эрүүл мэндийн зардлаас 4,093.0 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 4 зорилтын хүрээнд 43 заалт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.2 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>154,847,829.63</u></b>	<b><u>153,016,923.46</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	39,149,319.10
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	39,149,319.10
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	39,149,319.10
31211	Төрийн сангийн харилцах	00.00	39,149,319.10
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	53,379,954.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	52,557,400.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	822,554.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	822,554.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	101,467,875.63	113,867,604.36
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	47,482,787.27	50,400,040.95
35130	Эм боох материал	47,482,787.27	50,400,040.95
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,446.00	00.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	53,980,642.36	63,467,563.41
35410	Бичиг хэргийн материал	1,664,131.00	2,490,750.00
35420	Аж ахуйн материал	18,058,208.00	10,932,108.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,560,000.00	950,000.00
35440	Түлш, шатах тослох материал	663,402.27	565,122.27
35450	Барилгын засварын материал	1,412,000.00	00.00
35460	Хүнсний материал	1,270,175.09	10,295,500.59
35470	Бусад хангамжийн материал	29,352,726.00	38,234,082.55
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>561,967,693.23</u></b>	<b><u>734,697,461.24</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	561,967,693.23	734,697,461.24
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	547,931,693.23	719,561,461.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	464,023,880.00	642,023,880.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-54,267,149.08	-68,027,911.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,739,238.00	71,739,238.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,101,621.46	-39,668,896.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	174,425,900.40	223,625,501.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95,311,242.26	-125,084,337.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,147,932.00	35,751,532.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,725,244.37	-20,797,544.56
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,036,000.00	15,136,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,036,000.00	15,136,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>716,815,522.86</u></b>	<b><u>887,714,384.70</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>716,815,522.86</u></b>	<b><u>887,714,384.70</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	716,815,522.86	887,714,384.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	385,375,911.00	385,375,911.00
51101	Өмч: - төрийн	385,375,911.00	385,375,911.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	120,747,522.81	291,646,384.65
51210	Өмнөх үеийн үр дүн	120,747,522.81	120,747,522.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	170,898,861.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,692,089.05	210,692,089.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>716,815,522.86</u></b>	<b><u>887,714,384.70</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/Төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,130,085,424.80</b>	<b>1,075,881,242.97</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>368,429,554.80</b>	<b>234,460,882.97</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	368,429,554.80	234,460,882.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	368,429,554.80	234,460,882.97
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	368,429,554.80	234,460,882.97
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>294,888,870.00</b>	<b>841,420,360.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	466,767,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	222,324,480.00	8,623,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	339,800.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	550,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,408,130.00	1,383,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	285,350.00	200,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	32,937,500.00	40,398,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,937,500.00	40,398,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	39,626,890.00	792,399,360.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,626,890.00	792,399,360.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,006,714,404.44</b>	<b>904,982,381.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,006,714,404.44</b>	<b>904,982,381.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	957,314,404.44	904,982,381.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	394,558,523.00	473,046,148.60
210101	Үндсэн цалин	394,558,523.00	321,369,027.60
210102	Нэмэгдэл	00.00	121,822,771.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,291,000.00
210104	Урамшуулал	00.00	26,563,350.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,846,320.00	69,916,000.38
210201	Тэтгэврийн даатгал	37,717,462.00	51,492,888.63
210202	Тэтгэмжийн даатгал	3,955,486.00	4,831,826.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,164,388.00	3,818,420.91
210204	Ажилгүйдлийн даатгал	718,612.00	869,934.53
210205	Эрүүл мэндийн даатгал	7,290,372.00	8,902,930.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28,940,500.00	32,600,000.02
210301	Гэрэл, цахилгаан	2,700,643.00	3,570,937.00
210302	Түлш, халаалт	25,639,857.00	26,847,407.82
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	2,181,655.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	58,250,058.00	100,214,242.20
210401	Бичиг хэрэг	4,317,219.00	6,415,081.00
210402	Тээвэр, шатахуун	26,191,989.00	36,019,691.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,060,000.00	3,212,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,680,850.00	54,567,170.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	364,521,728.83	132,106,348.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	348,409,365.13	117,185,122.44
210502	Хоол, хүнс	16,112,363.70	14,921,226.50

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,234,000.00	1,486,000.00
210702	Дотоод албан томилолт	1,234,000.00	1,486,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,422,360.00	8,873,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,512,000.00	7,714,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,000.00	235,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	21,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	49,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	208,000.00	91,860.00
210807	Газрын төлбөр	140,360.00	60,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,540,914.61	86,740,580.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,709,430.00	22,567,148.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,831,484.61	64,173,432.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,400,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,400,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,900,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,500,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>123,371,020.36</b>	<b>170,898,861.84</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,000,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,000,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15,000,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>108,371,020.36</b>	<b>170,898,861.84</b>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	385,375,911.00	210,692,089.05	120,747,522.81	716,815,522.86
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	385,375,911.00	210,692,089.05	120,747,522.81	716,815,522.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	385,375,911.00	210,692,089.05	120,747,522.81	716,815,522.86
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	170,898,861.84	170,898,861.84
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	385,375,911.00	210,692,089.05	291,646,384.65	887,714,384.70

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>709,098,470.00</b>	<b>894,387,760.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>52,967,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	52,967,400.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	52,557,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	52,557,400.00
120009	Бусад орлого	00.00	410,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>709,098,470.00</b>	<b>841,420,360.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	466,767,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>169,767,080.00</b>	<b>8,623,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	339,800.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	550,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,408,130.00	1,383,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	285,350.00	200,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>32,937,500.00</b>	<b>40,398,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,937,500.00	40,398,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>39,626,890.00</b>	<b>792,399,360.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,626,890.00	792,399,360.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>696,428,470.00</b>	<b>802,391,040.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>696,428,470.00</b>	<b>802,391,040.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>647,028,470.00</b>	<b>802,391,040.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>394,558,523.00</b>	<b>485,664,020.00</b>
210101	Үндсэн цалин	245,644,385.00	298,598,067.00
210102	Нэмэгдэл	100,667,146.00	145,309,758.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,522,792.00
210104	Урамшуулал	42,803,826.00	35,973,403.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,443,166.00	1,260,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,846,320.00</b>	<b>57,708,128.98</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,131,940.00	40,941,360.01
210202	Тэтгэмжийн даатгал	3,875,098.00	4,315,631.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,136,949.00	3,425,325.13
210204	Ажилгүйдлийн даатгал	826,159.00	809,278.01
210205	Эрүүл мэндийн даатгал	7,876,174.00	8,216,534.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,940,500.00</b>	<b>32,600,000.02</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,700,643.00	3,570,937.00
210302	Түлш, халаалт	25,639,857.00	26,847,407.82

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	600,000.00	2,181,655.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>54,512,697.00</b>	<b>65,026,057.20</b>
210401	Бичиг хэрэг	5,346,450.00	4,542,300.00
210402	Тээвэр, шатахуун	27,008,797.00	35,098,857.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,060,000.00	3,212,300.00
210404	Ном, хэвлэл	165,000.00	346,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,745,450.00	9,558,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,187,000.00	12,268,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>88,979,430.00</b>	<b>91,573,474.70</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,991,263.00	66,106,574.70
210502	Хоол, хүнс	16,988,167.00	24,633,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	833,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,707,000.00</b>	<b>38,383,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,210,000.00	2,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,500,000.00	13,466,000.00
210604	Урсгал засвар	3,997,000.00	22,317,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,234,000.00</b>	<b>1,594,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,234,000.00	1,594,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,072,360.00</b>	<b>11,693,460.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,162,000.00	8,221,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,000.00	235,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	21,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	49,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	208,000.00	91,860.00
210807	Газрын төлбөр	140,360.00	60,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	2,313,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,177,640.00</b>	<b>18,148,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,177,640.00	18,148,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,400,000.00</b>	<b>00.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>49,400,000.00</b>	<b>00.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	49,400,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>12,670,000.00</u></b>	<b><u>91,996,719.10</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>12,670,000.00</b>	<b>52,847,400.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,670,000.00</b>	<b>52,847,400.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>12,670,000.00</b>	<b>52,847,400.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,670,000.00	52,847,400.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-12,670,000.00</u></b>	<b><u>-52,847,400.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>39,149,319.10</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>39,149,319.10</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Биелэлт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	892,688,900.00	855,238,440.90	-37,450,459.1	95.8
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	892,688,900.00	855,238,440.90	-37,450,459.1	95.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	892,688,900.00	855,238,440.90	-37,450,459.1	95.8
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	490,674,200.00	485,664,020.00	-5,010,180.0	99.0
210101	Үндсэн цалин	282,882,700.00	298,598,067.00	15,715,367.0	105.6
210102	Нэмэгдэл	148,131,500.00	145,309,758.00	-2,821,742.0	98.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,666,600.00	4,522,792.00	-7,143,808.0	38.8
210104	Урамшуулал	43,000,000.00	35,973,403.00	-7,026,597.0	83.7
210105	Гэрээт ажлын хөлс	4,993,400.00	1,260,000.00	-3,733,400.0	25.2
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,334,200.00	57,708,128.98	-3,626,071.0	94.1
210201	Тэтгэврийн даатгал	41,707,400.00	40,941,360.01	-766,040.0	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	4,906,700.00	4,315,631.41	-591,068.6	88.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,925,400.00	3,425,325.13	-500,074.9	87.3
210204	Ажилгүйдлийн даатгал	981,300.00	809,278.01	-172,022.0	82.5
210205	Эрүүл мэндийн даатгал	9,813,400.00	8,216,534.42	-1,596,865.6	83.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,600,000.00	32,600,000.02	0.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,700,000.00	3,570,937.00	-129,063.0	96.5
210302	Түлш, халаалт	27,700,000.00	26,847,407.82	-852,592.2	96.9
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	2,181,655.20	981,655.2	181.8
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	69,982,200.00	65,026,057.20	-4,956,142.8	92.9
210401	Бичиг хэрэг	4,542,300.00	4,542,300.00	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	40,055,000.00	35,098,857.20	-4,956,142.8	87.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,212,300.00	3,212,300.00	0.0	100.0
210404	Ном, хэвлэл	346,000.00	346,000.00	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,558,200.00	9,558,200.00	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,268,400.00	12,268,400.00	0.0	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	113,966,500.00	91,573,474.70	-22,393,025.3	80.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,499,600.00	66,106,574.70	-22,393,025.3	74.7
210502	Хоол, хүнс	24,633,400.00	24,633,400.00	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	833,500.00	833,500.00	0.0	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	72,131,200.00	72,131,200.00	0.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,643,800.00	28,643,800.00	0.0	100.0
210602	Тавилга	7,703,600.00	7,703,600.00	0.0	100.0
210603	Хөдөлмөр	13,466,000.00	13,466,000.00	0.0	100.0

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	хамгааллын хэрэглэл				
210604	Урсгал засвар	22,317,800.00	22,317,800.00	0.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,598,000.00	1,594,000.00	-4,000.0	99.7
210702	Дотоод албан томилолт	1,598,000.00	1,594,000.00	-4,000.0	99.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний хураамж ажил, төлбөр,</b>	30,910,100.00	30,793,460.00	-116,640.0	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,321,700.00	27,321,700.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	700,000.00	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	235,500.00	235,500.00	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	21,000.00	21,000.00	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	49,500.00	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	208,500.00	91,860.00	-116,640.0	44.1
210807	Газрын төлбөр	60,500.00	60,500.00	0.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,313,400.00	2,313,400.00	0.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19492500.00	18148100.00	-1,344,400.0	93.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,492,500.00	18,148,100.00	-1,344,400.0	93.1
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	892,688,900.00	893,977,760.00	-1,288,860.0	100.1
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	41,977,200.00	40,398,000.00	1,579,200.0	96.2
132001	Орон нутгийн төсвөөс	41,977,200.00	40,398,000.00	1,579,200.0	96.2
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	768,047,900.00	792,399,360.00	24,351,460.00	103.2
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	768,047,900.00	792,399,360.00	24,351,460.00	103.2
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	21,483,400.00			0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,483,400.00			0.0
131100	<b>Нэмэлт дээд шатны төсвөөс санхүүжих</b>	61,180,400	61,180,400	0.0	100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,383,000	-1,383,000	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		200,000	-200,000	
131107	Эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлого	61,180,400	59,597,400	1,583,000	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	39,149,319.10	39,149,319.1	

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	33.00	33.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн гүйцэтгэлийн нэмэлт тайлан байхгүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

#### Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан<sup>1</sup> 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан<sup>2</sup> тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.0

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний

<sup>1</sup> "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай"

<sup>2</sup> "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай"

байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу байгууллагын даргын 2022 оны 02 сарын 01-ны өдрийн А/10 дугаар тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 заалт бүхий 7 ажлын хүрээнд графикт хяналт шалгалтыг зохион байгуулж дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. Тухайлбал: Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

Нягтлан бодох

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох

бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 170,898.8 мянган төгрөгөөр буюу 23.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	39,149.3	-39,149.3
Авлага	53,379.9	0,0	53,379.9
Бараа материал	101,467.9	113,867.6	-12,399.6
Үндсэн хөрөнгө	561,967.7	734,697.5	-172,729.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>716,815.5</b>	<b>887,714.3</b>	<b>170,899.5</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	716,815.5	887,714.3	170,898.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>716,815.5</b>	<b>887,714.3</b>	<b>170,898.8</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 39,149.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 12,399.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 172,729.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 236,903.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 52,847.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй буюу улсын төсвийн хөрөнгөөр 24,055.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 160,000.0 мянган төгрөгийн цэвэр бохир усны цооногтой болсон ба барилгын сайжруулалтаар бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгал санаас 710,439.2 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжилт 33,207.7 мянган төгрөгийн санхүүжилт байна. Нийт зарлагыг 743,646.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хангамж бараа материалын зардлыг 188,977.8 мянган төгрөгөөр бууруулж, нийт санхүүжилт анх 554,669.1 мянган төгрөгөөр батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 41,997.2 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих дүнг 768,047.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 792,399.3 мянган төгрөг, даатгалын нэмэлт санхүүжилтээр 59,597.4 мянган төгрөг, дээд шатнаас 1,383.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 200,00 төгрөг санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 39,149.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 40,398.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл байхгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 855,234.4 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 37,400.0 мянган төгрөгийн үлдэгдэл зарцуулаагүйтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	488,815.3	458,332.9	30,400.0	93,8%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	300,716.0	295,327.0	5,400.00	98%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	61,180.4	61,180.4	0	100%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	36,100.0	36,100.0	0	100%
5	Нийтлэг үйлчилгээ	5,877.2	4,298.0	1,600.00	73%
	Нийт дүн	892,688.9	855,238.4	37,400.00	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 52,557.4 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Эрүүл мэндийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,006,714.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 20,134.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 14,094.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 59,151.4 мянган төгрөгийн 5 гүйлгээ мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж хүргүүлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар байгууллагын бүртгэл, тайлагнал, материалын эмх цэгц, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 3 зөвлөмжийг өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	15,000.0	3	15,000.0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>15,000.0</b>	<b>3</b>	<b>15,000.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эм 42,244.2 мянган төгрөг, тоног төхөөрөмж 26,683.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 78,711.6 мянган төгрөгийн алдаа илрүүлж алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

##### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

##### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

##### 5.4 Зөвлөмж

Аудитаар 3 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нийгмийн эрүүл мэндийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн зардлаас 4,093.0 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцээгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

#### 2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 7,557.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж тайлагнах

#### 3. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү 7,909.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>3</sup> дэхь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

**4. Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 59,151.4 мянган төгрөгийн 5 гүйлгээ мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж нь:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 202 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг зориулалтаар нь зарцуулаагүй	1	4,093.0					1	4,093.0				
Анхан шатны баримт дутуу	1	7,557.4					1	7,557.4				
Хоол хүнсний нөөц их хэмжээгээр бэлтгэсэн	1	7,909.8					1	7,909.8				
Дүн	1	19,560.2					1	19,560.2				

<sup>3</sup> "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй 5 байна.	1	59,151.4					1	59,151.4
Дүн	1	59,151.4					1	59,151.4

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

